

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол улсын Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан бүтэц дүрмийн дагуу 2022 оны 03 сард Соёл урлагийн газар байгуулагдсан. Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Ж.Даваадамдин томилогдон ажиллаж байгаа бөгөөд Соёл урлагийн хэлтэс 5, Захиргаа удирдлагын хэлтэс 3 нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.


№	Албан тушаал	Төрийн алба хаасан хугацаа	Мэргэжлийн эсэх
1	Дарга	9	Тийм
2	Соёл урлагийн хэлтсийн дарга	26	Тийм
3	Соёлын өвийн асуудал хариуцсан ахлах	11	Тийм
4	Төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах	8	Тийм
5	Урлаг, уран бүтээл хариуцсан мэргэжилтэн	8	Тийм
6	Соёл гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	11	Тийм
7	Төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан мэргэжилтэн	5	Тийм
8	Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн	1	Тийм
9	Архивч-бичиг хэрэг	1	Тийм

Хөвсгөл аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран Төрийн захиргааны албан хаагчдын тусгай шалгалтыг 2022 оны 11 дүгээр сарын 22-нд зохион байгуулахаар нээлттэй зарлаж, шалгалтад тэнцсэн албан хаагчдын Төрийн албаны салбарын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 89 дүгээр тогтоолын дагуу Соёл гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Галтболд, Төлөвлөлт, тайлагналт, цахимжилтын асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Санчирдулам, Урлаг уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг, Хяналт, шинжилгээ үнэлгээ статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Д.Пагмадулам нар нь 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар төрийн захиргааны жинхэнэ албан хаагчаар томилогдон ажиллаж байна. Хөвсгөл аймаг дахь ТАСЗ-ийн 75, 76 дугаартай тогтоолоор нэр дэвшсэн албан хаагчдын ХАСУМ-г хянуулахаар АТГ-д хүргүүлсэн.

Салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал:

Хөвсгөл аймагт мэргэжлийн байгууллага болох ХДТ, ОНСМ, ННС, орон нутгийн анхан шатны нэгж 23 соёлын төв, нийт 26 байгууллагад 233 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Насны байдлаар авч үзвэл 20-34 хүртлэх насны 112 буюу 47,1%, 35-50 хүртлэх насны 104 буюу 44,21%, 50-аас дээш насны 20 буюу 8,67 %-ийг эзэлж байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл магистр 12, бакалавр 159, дипломын дээд боловсролтой 7, тусгай мэргэжлийн 11, бүрэн дунд боловсролтой 9, бүрэн бус дунд боловсролтой 35 албан хаагч ажиллаж байна.



Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч"- ийг сонгон шалгаруулах шалгалтыг 2022 оны 04, 07, 11 дүгээр сард тус тус зохион байгуулж Ханх, Эрдэнэбулган, Улаан-Уул, Баянзүрх сумдын соёлын төвийн даргаар Төрийн албаны шалгалтад орж шалгуур хангасан мэргэжлийн хүн томилогдлоо. Соёлын салбарын хүний нөөцийн мэдээллийн санг 2022 оны байдлаар шинэчлэн гаргахад аймгийн хэмжээнд тус салбарын мэргэжлийн боловсон хүчний хангалт 58% болж өмнөх оноос 5 хувиар нэмэгдсэн байна.

Соёл урлагийн газраас салбарын байгууллагын дарга нартай сар бүрийн эхний 7 хоногт цахим хурал хийж хэвшсэн бөгөөд цаг үеийн болон үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, холбогдох зөвлөмжийг өгч, мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна.

Соёл урлагийн салбарын үйл ажиллагаатай танилцлаа.

Соёл, урлагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу энэ онд 22 сумын соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж, байшин барилга, тоног төхөөрөмжийн болон орон нутгийн иргэдээс соёлын төвийн үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн үнэллээ. Энэ үеэр албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлтэй танилцаж, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хэрэгжилт, анхаарах асуудлаар зөвлөн тусалж, сум, орон нутгийн удирдлагуудтай уулзан соёлын төвийн үйл ажиллагааны талаар санал солилцлоо. Мөн сумын иргэдэд "Соёлын тухай хууль" болон салбарын бусад хууль тогтоомж, аймгийн хэмжээнд соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх зорилгоор соёлын төвтэй хамтран уулзалт цэнгүүн зохион байгууллаа.



ХОЁР. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ СОЁЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН УЯЛДААГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг удирдлага болгон Соёлын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилтийг хувь:

2022 онд Соёлын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт

Суурь түвшин 60%
Гүйцэтгэлийн хувь 81.55%

“Соёл-Олон ястны өв” хөтөлбөр

Суурь түвшин 60%
Гүйцэтгэлийн хувь 78.6%

Аймаг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах

Суурь түвшин 60%
Гүйцэтгэлийн хувь 90%

“Иргэдийн оролцоонд тулгуурласан өв хамгаалал” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах

Суурь түвшин 60%
Гүйцэтгэлийн хувь 90%

Соёлын сайдаас Хөвсгөл аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээг холбогдох соёл, урлагийн байгууллагууд хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэрээнд тусгагдсан цагалбарын дагуу тайлагнан аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэн хянуулж, аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээр хяналт-үнэлгээ хийлгэж байна. 2022 онд Соёлын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт 81.55%-ийн биелэлттэй байна.

Аймгийн Засаг даргын “Соёл олон ястны өв” хөтөлбөрийн хүрээнд Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах арга хэмжээнд зориулан Орон нутгийн хөгжлийн сангаас 10 сая төг батлагдсан ба тоног төхөөрөмжийг “Саяны цоохор ирвэс” ХХК -тай гэрээ байгуулан нийлүүллээ. АНУ-ын Монтана мужийн эгч дүү орнууд төслийн санхүүжилтээр Чандмань-Өндөр суманд “Буриад урианхай угсаатны соёл урлаг”-ийн наадмыг амжилттай зохион байгууллаа. Уг наадамд Ханх, Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын 70 гаруй ардын авьяастан оролцсон юм. “Тогтвортой ноос ноолуурын эвсэл” төсөлтэй хамтран Хөвсгөл аймгийн Рашаант, Төмөрбулаг, Галт, Цагаан-Уул сум болон Мөрөн сумын Гурван-Эрдэнэ сургуулийн 200 хүүхдэд “Шинэ зууны малчин” хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүд мал маллах ухаан, байгаль дэлхийгээ хайрлах, уламжлалт өв соёлоос суралцах зэрэг амьдрах ухааны олон чадварт суралцлаа. Аймгийн Зураач урчуудын холбоотой хамтран Хөвсгөл аймгийн уугуул, зураач Д.Цэнгүнжавын “Хөвсгөл сайхан нутаг” уран бүтээлийн үзэсгэлэнг 2022 оны 06 сарын 10-20-ны хооронд зохион байгууллаа. Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ахмад кино механикч СТА Ч.Уртнасан, Н.Наранцэцэг нарын санаачлагаар “Сэтгэлд хоногшсон аялгуу” Монгол киноны дууны наадмыг 2022 оны 06 сарын

18-ны өдөр зохион байгууллаа. Наадамд Хөвсгөл аймгийн киноны салбарын ахмадууд урилгаар хүрэлцэн ирж аймгийн Соёл, урлагийн газрын даргатай уулзаж санал бодол солилцлоо. Уг наадмын шагналын сан болон бусад шаардлагатай зардлыг Ч.Уртнасан гуайн гэр бүлээс санхүүжүүлсэн байна.

Аймаг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд соёл, урлагийн салбарт хэрэгжих 7 арга хэмжээ тусгагдан хэрэгжиж байна. Үүнд: Соёлын төвийн номын сангийн фонд баяжуулахад зориулан Соёлын яамнаас олгосон 500,0 төгрөгийн санхүүжилтээр нэг сум дунджаар 22 ширхэг ном, нийт 11,500,000 төгрөгийн үнэ бүхий 506 ширхэг номын баяжилт хийгдсэн байна. Төсвийн санхүүжилтээр аймгийн хэмжээнд 7.978.000 төгрөгийн 432 ширхэг, хандиваар 2,346,800 төгрөгийн 260 ширхэг, нийт 10.324.800 төгрөгийн 692 ширхэг ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр сан хөмрөгийг нэмэгдүүлсэн байна. ОНСМ-н “Байнгын үзүүллэгийн танхим”-ын гэрэлтүүлгийн системийг иж бүрэн шинэчлэх ажлыг №ХӨАОНӨГ/202212022-09 тоот гэрээний дагуу “Хөвсгөл мөнгөн од” ХХК төлөвлөгөөт хугацаанд нь хийж гүйцэтгэлээ. Аймгийн 23 сумын номын сангийн сан хөмрөгийг цахим мэдээллийн санд шилжүүлэх ажлыг зохион байгууллаа. Хөвсгөл аймгийн 90 жилийн ойн хүрээнд “Хөх сувдын орон-Хөвсгөл мину” фото альбомыг эмхтгэн бэлтгэж 500 ш-ийг “Бит пресс” компанид хэвлүүллээ. СББӨ-ийн 300 өвлөн уламжлагчийг холбогдох бүртгэлийн маягт (Маягт 3)-аар бүртгэн баримтжууллаа. Рашаант сумын Соёлын төвийн дээврийн их засварын тендерийг зарлаж “Тэмээн” ХХК хийж гүйцэтгэлээ.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 19-р тогтоолоор “Иргэдийн оролцоонд тулгуурласан өв хамгаалал” хөтөлбөр хэрэгжиж байна. 15 сумын 129 малчин иргэдтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалыг харж хамгаалах гэрээг тогтмол байгуулан ажиллаж байна. Үүнээс шинээр 50 иргэнтэй гэрээ байгуулан улсын хамгаалалтад орших 2 дурсгал, аймгийн хамгаалалтад орших 15 дурсгалыг гэрээгээр хариуцуулаад байна.


Аймгийн Соёл, урлагийн салбарын хөгжлийн стратеги төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон Соёлын яамны стратеги төлөвлөгөө, бодлогын бусад баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан. Стратеги төлөвлөгөөний төслийг Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.

ГУРАВ. ТӨРӨӨС СОЁЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

Соёлын үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соёлын боловсрол, соён гэгээрүүлэх ажлын талаар:

Хос бичигтэн байгууллага

Соёлын яамны дээрх уриалгыг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд соёл урлагийн байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. Аймгийн Соёл урлагийн газраас МУ-ын гавьяат багш Д.Сайнтогтох багштай хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын албан хаагчдад монгол бичгийн хичээлийг 2022 оны 05 сараас эхлэн 7 хоногт 1 удаа зохион байгуулж хэвшсэн бөгөөд мэдлэгээ бататгах зорилгоор “Хүмүүн бичиг” сонин захиалан уншиж байна. Мөн цахим бичвэрийн мэдлэгээ тогтмол сайжруулж хэвлэлийн эх бэлтгэлийн бичвэрийн 50 хувийг монгол бичгээр бичиж байна. Аймгийн Нийтийн номын сан, Төв музейн хамт олон хос бичигтэн болох хөдөлгөөн өрнүүлэн мэргэжлийн багшийн сургалтад 7 хоногт 1 удаа хамрагдаж, байгууллага дотроо уралдаан зарлах, монгол бичгээр хэвлэгдсэн ном сонингоор үзэсгэлэн гаргах, уран бичлэгийн сургалтад хамрагдах зэрэг олон арга хэмжээг зохион байгуулж монгол бичгийн хэрэглээний орчин бүрдүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.



УИХ-ын даргын ивээл дор зохион байгуулагдсан 31, 32 дахь удаагийн “Номын баяр”



“Дэлхийн номын өдөр”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” хавар, намрын арга хэмжээ, “Соёлын орон зай”, “Соёлын бүтээлч сар” зэрэг соён гэгээрүүлэх 6 чиглэлийн хүрээнд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан 52 төрлийн арга хэмжээг аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, ЕБС, СӨБ, иргэд уншигчдын дунд амжилтай зохион байгууллаа. Уг арга хэмжээг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 48900 уншигч, ирэгсэдийг хамруулсан байна. “Явуулын номын сан” үйлчилгээ нь аялал жуулчлалын бүсүүдэд буюу “Соёмбо” цогцолбор, болон “Шинэ Мөрөн” зэрэг үйлчилгээний төвүүдэд ном байршуулсан. Аймгийн 23 сумын номын сангийн сан хөмрөгийг нэгдсэн цахим мэдээллийн санд шилжүүлэх, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгууллаа. Мөн Номын баяр арга хэмжээний хүрээнд ХЦ-ийн 0257 дугаар ангийн Соён гэгээрүүлэх албатай хамтран ХЦ-ийн 11 салбарт нүүдлийн номын санг 6 сарын хугацаанд аялуулж 430 гаруй уншигчдыг хамрууллаа. Мөн Хилийн цэргийн 0257 дугаар ангитай хамтарч “Номтой өглөө” өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж 82 албан хаагчдад шинээр уншигчдын карт нээж үйлчилсэн.



“Үндэсний бичиг үсгийн баяр-2022” арга хэмжээний хүрээнд соёлын төвийн номын санчдын дунд “Бийрэн бичиг” уралдаан зарлаж, ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гарган, шилдэг бүтээлийг тодруулан урамшууллаа. “Үндэсний бичиг үсгийн баяр-2022” -ын арга хэмжээнд 21 сумын номын санч, Мөрөн сумын ЕБС-ын 7 сургуулийн 8 багш, 33 сурагч оролцлоо. Хөвсгөл Арт галерейд Эрдмийн далай цогцолбор сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Н.Нямчимэгийн “Үсэг урлалд амилахуй” бие даасан үзэсгэлэнг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулж олны хүртээл болголоо. Мөн аймгийн Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран 2022 оны 5 дугаар сард Мөрөн сумын ЕБС-иудын дунд “ХҮМҮҮН БИЧИГ” монгол бичгийн уралдаан зарлаж 9 сургуулийн 30 сурагч оролцлоо.

Угийн бичиг

Хөвсгөл аймгийн ГБХЗХГ-тай хамтран угийн бичиг хөтлөх аяныг зохион байгуулсан бөгөөд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, арга зүйгээр хангах, айл өрхүүдэд угийн бичгээ хөтлөх санаачлагыг нь дэмжих үүднээс “Ураг удам” угийн бичиг хөтлөх уралдааныг зарласан. Уралдаанд нийт 21 бүтээл ирснээс тэргүүн байранд Монгол улсын гавьяат багш П.Лхагвасүрэн, Дэд байранд Монгол улсын гавьяат багш Д.Сайнтогтох, Гутгаар байранд Бүрэнтогтох сумын иргэн Ц.Сонинпил, Тусгай байранд Мөрөн сумын иргэн Б.Пүрвээ, Тусгай байранд Рашаант сумын Раш овгийн удмынхан шалгарч мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнууллаа. Энэхүү аяны хүрээнд угийн бичиг хөтлөх мэдлэг олгох 5 цахим контент бүтээж олны хүртээл болголоо.



Соёл урлагийн газрын мэргэжилтнүүд Хөвсгөл аймгийн Галт, Их-Уул, Тосонцэнгэл, Алаг-Эрдэнэ сумын 387 малчин, төрийн албан хаагчдад “Угийн бичгийн сургалт” зохион байгууллаа. Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх түүний ач холбогдлыг нийтэд сурталчлан таниулах зорилгоор Аймгийн ХДТ-ын хамт олон Ц.Ням-Осорын зохиол “Хайрын булингар” эмгэнэлт драмын жүжгийг Мөрөн хотод 10-р сарын 19-21-ний өдрүүдэд, Тосонцэнгэл, Их-уул, Тариалан сумд 11 сарын 07-09-ний өдрүүдэд тоглож үзэгчдийн хүртээл болголоо.

“Аймгийн 90 жил”-ийн ой

Ардын хувьсгалын 100,101 жил, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг СУГ-ын дарга Ж.Даваадамдин найруулж амжилттай зохион байгууллаа. Нээлтийн хөтөлбөр нь Хөвсгөл нутгийн 6 угсаатны дуу хуурын дээжээс бүрдсэн бөгөөд “Их хэнгэргийн дуу” бүхий 333 бөөгийн бүжиг нь үзэгчдийн сонирхлыг ихээхэн татаж чадлаа. Хөвсгөл аймгийг “Соён гэгээрүүлэгчдийн өлгий нутаг” хэмээн зарлаж, нутгаасаа төрөн гарсан алдартнуудыг алдаршуулах зорилгоор наадмын талбайд тайз болон Төв музейд алдрын танхимыг дэглэлээ. Мөн баяр наадмын хүндэтгэлийн тоглолтыг Хөвсгөл аймгаас төрөн гарсан хөгжмийн зохиолч, ая зохиогч, яруу найрагчдын сор бүтээлийн дээжээс бүрдсэн байдлаар зохион байгуулсан юм. Наадмын зохион байгуулалтын хүрээнд баяр наадмын хандивын хөрөнгөөр 30,0сая төгрөгийн төсөвтэй амьд хөгжмийн “Мөрөн” хамтлагийг сэргээн байгуулж, наадмын хаалтын тоглолтыг хийлээ. Мөн ойн хүрээнд 23 сумын байгаль, түүх соёлын дурсгалт газруудын танилцуулга бүхий, байгаль болон соёлын аялал жуулчлалын гарын авлага болох “Хөх сувдын орон-Хөвсгөл минь” фото альбомыг эмхтгэн бэлтгэж 500 ширхэгийг “Бит пресс” компанид хэвлүүллээ. Ийнхүү Хөвсгөлчүүд 90 жилийн түүхээ соён гэгээрүүлэгчдийн алдар гавьяагаар баринтаглаж, ойн баяр наадмаа амжилттай зохион байгууллаа.



“МУСГЗ Ж.Бадраагийн дууг хэн сайн дуулах вэ” уралдаан

Хөвсгөл аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баярыг тохиолдуулан 20-р зууны нэрт соён гэгээрүүлэгч, “МУСГЗ Ж.Бадраагийн дууг хэн сайн дуулах вэ” аймгийн уралдааныг аймгийн СУГ-ын зүгээс зохион байгууллаа. Тус тэмцээнд 20 сумын шилдэг оролцогчид

өрсөлдөж, тэргүүн байранд Галт сумаас оролцогч А.Гантулга, дэд байранд Тариалан сумаас оролцогч Б.Лхагвадулам, гутгаар байранд Мөрөн сумаас оролцогч Б.Батзориг, тусгай байранд Арбулаг сумаас оролцогч Э.Болорцэцэг, Рэнчинлхүмбэ сумаас оролцогч Э.Эрдэнэбаяр нар шалгарлаа. Баяр наадмын өмнөх үдэш тус наадмын шилдэг оролцогчдын гала тоглолтыг зохион байгуулав.



“ХӨВСГӨЛИЙН ЦУУРАЙ - 3” УРАН ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

Баяр наадмын тохиолдуулан Мөрөн хотын Чингүнжавын талбайд Хөвсгөл аймгийн ЗУХ-ны гишүүд болон сумдаас ирсэн зураач, урчуудын бүтээлүүдийн үзэсгэлэнг зохион байгуулав. Монголын урчуудын эвлэлийн 80, Хөвсгөл аймгийн Зураач урчуудын холбооны 75 жилийн түүхэн ойгоороо ахмад зураач Б.Төртогтох, зураач багш Ц.Баянжаргал нар МУЭ-ийн гишүүн болсон байна.





“Хөвсгөл судлал” эрдэм шинжилгээний бага хурал



Монголын төр, боловсрол, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, Монгол улсын хөдөлмөрийн баатар, төрийн шагналт, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Базарын Ширэндэвийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан “ХӨВСГӨЛ СУДЛАЛ” эрдэм шинжилгээний бага хурлыг Хөвсгөл аймгийн Соёл урлагийн газар санаачлан ШУА-ийн Философийн хүрээлэн, Засаг даргын тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Шинжлэх ухаан технологи, инновацын зөвлөл хамтран 2022 оны 11 сарын 11-ний өдөр ЗДТГ-ын Соёмбо танхимд зохион байгуулав. Бага хуралд ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, Доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэн, ШУА-ийн Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн ЭШТА доктор (Ph.D), профессор, ШУГЗ Н.Хишигт тэргүүтэй ШУА-ийн эрдэмтэн, судлаачид, Олон Улсын Монгол Судлалын Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, академич С.Чулуун, Удирдлагын академи, МУИС, ШУТИС, МУБИС, ХААИС-ийн багш эрдэмтэд, орон нутаг судлаачид илтгэл хэлэлцүүлээ. Түүнчлэн Хөвсгөл аймгийн Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл, Орон нутгийн залуу судлаач, эрдэмтэд, 23 сумын засаг дарга, Соёлын өвийн ажилтнууд, түүх нийгмийн ухааны багш нарын төлөөлөл, байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүд зэрэг 180 гаруй хүн оролцсон байна. Тус эрдэм шинжилгээний хурлын хүрээнд “Хөвсгөл судлал ба соёл судлал” сэдвээр шилдэг илтгэлийн уралдаан зарлаж шилдгүүдийг тодруулан “Нүүдэлчин монгол 2022” наадмын шагналын сангаас санхүүжүүлэн өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулав.






“Хөвсгөл соёлын мод” цахим контент

Аймгийн Соёл урлагийн газар орон нутгийн “Түмний ТВ”, “Далай ээж ТВ”-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан "ХӨВСГӨЛ СОЁЛЫН МОД" 24 удаагийн цуврал нэвтрүүлгийг бэлтгэж “Түмний ТВ”, “Далай ээж ТВ”-ийн эфирт болон цахим хуудсаараа дамжуулан үзэгчдэд хүргэлээ. Соёл урлагийн салбарт өрнөж байгаа үйл явдал, зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагааны талаар тухай бүрд нь мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэн ажиллаж байна.



Нийгмийн сүлжээнд салбарын мэдээ мэдээллийн түгээлт

“Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын <https://www.facebook.com/khvusgulsug/> фэйсбүүк хуудсанд салбарын мэдээ мэдээллийг тогтмол оруулан идэвхтэй хөтөлж өнөөдрийн байдлаар 5734 дагагчтай болсон. Цаг үеийн болон зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тогтмол, цахим хуудсанд байршуулж аймаг, сумдын хамгийн олон гишүүдтэй фэйсбүүк бүлгүүдэд хуваалцдаг. Байгууллагын 7 хоногийн тойм мэдээг 11 удаа, сарын тойм мэдээг 2 удаа, “Нүүдэлчин Монгол наадам”-ын мэдээ мэдээлэл, 10 хоногийн тойм мэдээг 6 удаа видео хэлбэрээр бэлдэж байгууллагын цахим хуудсаар түгээсэн байна. Соёлын яам, Агентлаг, соёлын салбарын болон бусад хамтран ажилладаг байгууллагын мэдээ мэдээллийг цахим хуудаснаа тогтмол хуваалцаж ажилладаг.



“Монгол бахархал-Бидний бахархал” аян

Соёлын бүтээлч сарын хүрээнд “Монгол бахархал-Бидний бахархал” аяныг аймгийн хэмжээнд зарласан бөгөөд дараах 2 зорилтыг дэвшүүлэн байгууллага, сумдад албан тоот, удирдамжийн хамт хүргүүлж хэрэгжилтийг дүгнэн шилдгүүдийг тодруулж шагнал гардууллаа.

1. Төрийн байгууллагууд “Түүхийн жимээр” байгууллага сурталчлах танхим, булантай болох /Сум, байгууллага бүр өөрийн байгууллагын түүх, уламжлал, онцлогийг илтгэн харуулсан танхим, буланг байгуулах, хэрэв танхимтай бол баяжуулна./
2. Оюуныг нээгч “Оюунтүлхүүр” судрын утга агуулга, төрт ёсны уламжлалыг судалж, танин мэдэх, түгээн дэлгэрүүлэх аян

Түүхийн жимээр

Тус аянд нийт 31 байгууллага тайлан ирүүлснээс Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0257-р анги, Политехникийн коллеж эхний 3 байранд шалгарлаа.



Оюунтүлхүүр аян

Их эзэн Чингис хааны билиг сургаалыг оршоосон “Оюунтүлхүүр” судрыг судалж, танин мэдэх, уран яруу унших, бусад бүтээлч ажил зохион байгуулж сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий энэхүү ажилд аймгийн ННС, 23 сумын Соёлын төв, ЕБС, СӨББ-ууд идэвхтэй оролцож олон бүтээлч ажлуудыг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд Улаан-Уул, Эрдэнэбулган, Цагаан-үүр сумын соёлын төвүүд шалгарлаа.



“Бүх нийтийн соёлын боловсрол олгох чиглэлээр сургалт, мэдээ мэдээллийг хүргэж ажилласан байдал”

Хөвсгөл аймгийн Рашаант, Их-Уул, Цагаан-Уул, Жаргалант, Тосонцэнгэл сумдад “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндсэн ойлголт”, төрийн албан хаагчийн ёс зүй зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Галт, Алаг-Эрдэнэ сумдад зохион байгуулагдсан “Залуу малчдын зөвлөгөөн”-д оролцон гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, мэдээллийг хүргэсэн ба малчин өрхөд зориулсан “Гэр бүлийн боловсрол”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Монголын уламжлалт гэр бүлийн харилцааны арга ухаан” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулснаар залуу гэр бүлүүд “гэр бүлийн үнэ цэнийг мэдэх, үр хүүхдээ зөв арга ухаанаар өсгөн хүмүүжүүлэх зэрэг соёлын боловсролд нь дэмжлэг үзүүллээ. Мөн Угийн бичгийн сургалтыг Алаг-Эрдэнэ, Их-Уул, Тосонцэнгэл суманд зохион байгууллаа. Төрийн албан хаагчид болон орон нутгийн иргэд, малчдын соёлын боловсролд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 10 удаагийн сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэж ажилласан байна.



Соёлын өвийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажлаас:

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого”

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого”-ын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 495 дурсгалт газрын 8546 дурсгал тоологдсон бөгөөд Байгалийн тогтоц, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан тооллогын ажил 98.6%-ийн гүйцэтгэлтэй байна.

9 сумын тооллогын ажилд СУГ-ын дарга, мэргэжилтнүүд, аймгийн Төв музейн дарга, эрдэм шинжилгээний ажилтан зөвлөн тусалж сумын ЗДТГ, багийн ЗД, Өвийн ажилтантай хамтран ажилласан бөгөөд тооллогын арга зүй, явцын талаар соёлын төвүүдэд утсаар болон цахимаар тогтмол мэдээлэл сургалт хийж ажиллалаа.



Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын цахим бүртгэл

Хөвсгөл аймгийн хэмжээнд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 905 хүн бүртгэлтэй байдаг бөгөөд 2022 оны 06 дугаар сарын байдлаар 300 өвлөн уламжлагчийг холбогдох бүртгэлийн маягт (Маягт 3)-аар бүртгэн баримтжууллаа. Аймгийн ИТХ-ын 56-р тогтоолоор батлагдсан "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч"-ийг тодруулах, батламжлах журмын дагуу 2022 онд Галт сумын уран дархан Г.Мядаг, Чандмань-Өндөр сумын гар урлаач М.Эрдэнэхуяг, Цагаан-Уул сумын Хотгойд дууч Л.Наранцэцэг нарт энгэрийн тэмдэг, батламж, 100.000 төгрөгийг гардууллаа. 12 дугаар сарын байдлаар Mongolow.mn цахим програмд 669 өвлөн уламжлагчийг цахимаар бүртгэсэн байна.

Мөрөнгийн хүрээ Гандандаржайлин хийдэд хадгалагдаж байгаа 3 дэсийн 209 ширхэг судрыг баримтат өвд бүртгэж улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд дамжуулсан. Мөн "Соёлын өв ба баримтат өвийн бүртгэл, хадгалалт" сэдвээр сумдын хүрээ хийдийн үйл ажиллагааг хариуцдаг 14 ламыг оролцуулсан сургалт зохион байгууллаа. Орон нутгийн иргэдийн гар дээр хадгалагдаж буй 350 гаруй баримтат өвийг Соёлын яамнаас ирүүлсэн маягтын дагуу бүртгэн баримтжуулаад байна.

“Нүүдэлчин Монгол-2022” аймгийн наадам

“Нүүдэлчин Монгол-2022” наадмын анхан шатны шалгаруулалтыг бүсийн хэлбэрээр зохион байгуулсан. Үүнд:

- “Буриад-Урианхайн урлаг соёлын наадам” Чандмань-Өндөр суманд
- “Халх, Хотгойд урлаг соёлын наадам” Жаргалант суманд
- “Дархад, Цаатан урлаг соёлын наадам” Рэнчинлхүмбэ суманд

Аймгийн наадамд нийт 467 өвлөн уламжлагч оролцсон байна.

Бүсийн наадмуудыг ардын урлагийн 6 төрлөөр, орон нутгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн гаргаж зохион байгуулсан бөгөөд Соёл урлагийн газрын дарга, мэргэжилтнүүд сумдын ЗДТГ, Соёлын төвүүдтэй хамтран ажиллалаа. Америкийн нэгдсэн улсын Монтана мужийн “Эгч дүү орнууд” төслөөс Буриад урианхай угсаатны урлаг соёлын наадмыг 5.0 сая төгрөгөөр санхүүжүүлэн оролцсон байна.



“Нүүдэлчин Монгол” дэлхийн соёлын фестиваль

2022 оны 08 сарын 11-14-ний өдрүүдэд УБ хотноо Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт зохион байгуулагдсан “Нүүдэлчин Монгол” – 2022 соёлын биет бус өвийн их наадамд Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын хамт олон Цагааннуур, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ сумдын ардын авьяастнууд, цаатан иргэд, гар урлалынхан, тогооч, тан баригч, бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, жолооч нийт 54 хүний бүрэлдэхүүнтэй оролцож Тэргүүн байр эзэллээ. “Цаатан” угсаатны уламжлал, соёл, ёс заншлыг илэрхийлсэн “Тайгын эгшиглэн” 40 минутын тоглолтыг дэглэн найруулж “Цаатны отог” дээр 3 өдрийн турш бүрэн хэмжээний тоглолтыг нийт 11 удаа, хэсэгчилсэн тоглолтыг 20 гаруй удаа толилууллаа. Удам дамжсан тан баригч М.Нямжав Хөвсгөлийн уул тайгын ай савд ургадаг нэн ховор болон ховор зүйл төрлийн эм, эмийн ургамлаар тан найруулан оролцож, гурван үе дамжсан удган Б.Мэндбаяр бөөгийн зан үйлийг үзүүлэв. Л.Бадамдоржийн гар урлал: Цааны аж ахуйг харуулсан уран зураг, амьтдын эвэр, мод ашиглан хийсэн жижиг бэлэг дурсгал, эсгийгээр хийсэн цаа буга, А.Давхарбаярын гар урлал: Ясан хундага, аяга, эврэн хутга, хүзүүний ясан зүүлт, цааны эвэр дээрх сийлбэр зураг, Б.Батзаяагийн гар урлал: Цааны эврээр хийсэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн, Б.Шинэцогт: Суран эдлэл, үйсэн сав, Амаржаргал: Арьсан ширдэг, богц, Н.Эрдэнэбилэг: Чулуун хөөрөг урлал зэрэг бүтээлүүдээр оролцлоо. Мөн Хөвсгөл аймгийн тогооч нарын холбооны 5 хүний бүрэлдэхүүнтэй баг “Загасны хорхог” нэрийн хоолоороо амжилттай оролцож өндөр үнэлгээ авав. Эвэр, суран эдлэл, үйсэн сав, Цаа буга болон түүний эд хэрэглэлийн зүйлээр урласан гар урлалын бүтээгдэхүүн ихээр борлогдсон нь тухайн бүтээлүүд хэрэглэгчийн сонирхол шаардлагыг хангасан болохыг илэрхийлж байлаа. Цаатны отогт үзэгч, зочдын давалгаа 3 өдрийн турш үргэлжилж, үзэгчдийн санал асуулгаар тэргүүлээ.

Наадамд оролцох зардлын тооцоог гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж наадмын 26.0 сая төгрөгийн санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж шийдвэрлэв.





Урлаг, уран бүтээл, уран бүтээлчдийг дэмжих чиглэлээр

“Цайны зам” соёлын наадам, ажил мэргэжлийн туршлага судлах аялал

Хөвсгөл аймгийн 21 сумын соёлын төвийн дарга, Соёл урлагийн хэлтсийн мэргэжилтнүүд нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй баг 2022 оны IX.25-X.01-ний өдрүүдэд Ховд хотноо зохион байгуулагдсан “Цайны зам” соёлын наадмыг үзэж сонирхох, Ховд, Завхан, Говь-Алтай аймгийн соёл урлагийн зарим байгууллагатай танилцаж туршлага судлах аяллыг амжилттай зохион байгууллаа. Аяллын туршид аймгийн театр, чуулга, музей, номын сан, зарим сумдын соёлын төв зэрэг 13 байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.



Аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлүүд дээр хамтран ажиллаж хяналтын үзлэгийг СУГ-ын дарга, мэргэжилтнүүд тогтмол хийж зөвлөн тусаллаа.

Хөгжимт драмын театрын 2022 оны онцлох уран бүтээлүүд:

- “Баавгай дуулах уу” хүүхдийн жүжиг /Мөрөн, Тариалан/
- Ш.Гүрбазар “Надаар тоглосон хайр” уянгын драмын жүжиг
- Ц.Ням-Осор “Хайрын булингэр” эмгэнэлт драмын жүжиг /Мөрөн, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан сумдад/
- “Цаатан түмний аялгуу” орчин цагийн этник тоглолт
- Хөвсгөл аймгийн Хөгжимт Драмын Театрын Жигжидийн Жаргалсайханы нэрэмжит Хөгжим ангийн уран бүтээлчдийн "Сэтгэлд хоногшсон аялгуу" тоглолт





ХДТ-ын хөгжим анги “Тэгэри” хамтлагийг шинээр байгуулсан бөгөөд Хөвсгөл нутгийн зургаан угсаатны ардын дуу хуурыг орчин үеийн хэлбэрт оруулан үндэсний хөгжмийн зэмсгээр тоглодог онцлогтой. 2022 онд тус хамтлаг Тэс нутгийн ардын дуу “Дэлтэй цэнхэр”, Т.Болорцэцэгийн найруулга “Тайгын эгшиг” үндэсний цөөхүүлд зориулсан уран бүтээлийг шинээр туурвисан байна. Хөгжимт драмын театрын 2022 оны өвөл цагийн үзвэрийн нээлт “Цаатан түмний аялгуу” бүрэн хэмжээний тоглолтод “Тэгэри” этник хамтлаг СТА Ц.Гангын найруулга “Хавцал”, дархад ардын дууны найруулга “Отог”, “Монгол цус” зэрэг ардын хөгжимд зориулсан бүтээлээс гадна уг тоглолтонд дуулагдсан ардын дуунуудыг этник хэлбэрт оруулан найруулснаар үзэгчдэд хүргэлээ. 2022 онд “Тэгэри” хамтлаг урын санд нийт 8 бүтээл шинээр нэмэгдсэн байна.



Зураач урчуудын бүтээлийн үзэсгэлэн

2022 онд аймгийн “Зураач урчуудын холбоо”-ноос нийт 17 үзэсгэлэнг зохион байгуулсан байна. Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулсан онцлох үзэсгэлэнгүүдээс дурдвал: Аймгийн 90 жилийн ойн баярын хүрээнд “Хөвсгөлийн цуурай-3” уран бүтээлийн үзэсгэлэн 2022 оны 07 дугаар сарын 30-аас 08 дугаар сарын 17-ны хооронд Хөвсгөл арт галерейд дэлгэгдлээ. Үзэсгэлэнгийн нээлтийн үйл ажиллагааг аймгийн төвийн “Чингүнжавын талбай”-д зохион байгуулсан бөгөөд үзэсгэлэнд 20 гаруй уран бүтээлчийн 90 гаруй бүтээл дэлгэгдсэн юм. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Цэцэгсийн дуулал” уран бүтээлийн үзэсгэлэн, Монголын багш нарын баярыг тохиолдуулан “Багшийн алдар-5” зураач урчууд, багш нарын хамтарсан үзэсгэлэнг амжилттай зохион байгууллаа. 2022 онд Монголын урчуудын эвлэлийн 80, Хөвсгөл аймгийн Зураач урчуудын холбооны 75 жилийн түүхэн ойгоор ахмад зураач Б.Төртогтох, зураач багш Ц.Баянжаргал нар МУЭ-ийн гишүүн болсон байна. “Соёлын орон зай” шилдэг уран бүтээл шалгаруулах уралдаант үзэсгэлэнг зохион байгуулж шилдгүүдийг шалгаруулан мөнгөн шагналаар урамшуулав.



Дархад дууны цомог

“Нүүдэлчин Монгол” фестивалийн шагналын сангаас /5сая ₮/ ивээн тэтгэж Улаан-Уул сумын соёлын төвийн ардын авьяастан Д.Агармаагийн “Дархад дууны цомог”-ийг хэвлүүлж, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн чуулганы үеэр цомогийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулав.



Хөвсгөл аймгийн УЗН 70 жилийн ой, “Хөх зул” хүүхдийн яруу найргийн наадам

Хөвсгөл аймгийн Утга зохиолын нэгдлийн 70 жил ойн арга хэмжээ, “Хөх зул” хүүхдийн яруу найргийн наадмыг УЗН-тэй хамтран зохион байгууллаа. “Хөх зул” наадмын уралдааныг 11 сарын 08-ны өдөр зарлаж нийт 57 хүүхдийн шүлэг ирснээс 6 бүтээлийн эздийг шалгаруулж аймгийн ХДТ-т зохион байгуулагдсан УЗН-ийн 70 жилийн ойн арга хэмжээнд оролцуулж шилдгүүдийг тодруулан шагналаа. УЗН-ийн ойн хүрээнд Цагаан-Үүр сумын уугуул, яруу найрагч Б.Батсайхан "Хар байцын мараа" яруу найргийн 2 дахь номынхоо нээлтийг амжилттай зохион байгуулав. /“Нүүдэлчин монгол” фестивалийн шагналын сангаас 6,0сая төг зарцуулав/





Хөвсгөлийн найрагчид яруу найргийн наадамд амжилттай оролцлоо.

Сэлэнгэ аймгийн “Утга зохиолын нэгдэл”-ийн 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Яруу найргийн наадам”-д Хөвсгөл аймгаас 5 яруу найрагч оролцож, 3 яруу найрагч 2,3,5-дугаар байрыг эзэллээ. Мөн “Болор цом” наадамд 3 яруу найрагч өрсөлдөж шагналт байранд шалгарсан. Эдгээр яруу найрагчдын наадамд оролцох замын зардлыг СУГ-аас шийдвэрлэв.



Соёлын төвийн бүжгийн багш нарыг чадавхжуулах сургалт

Хөвсгөл аймгийн бүжгийн холбоотой хамтран Соёлын төвийн бүжгийн багш нарыг чадавхжуулах 5 хоногийн сургалтыг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулж сертификат олголоо. Сургалтад Цагаан-Үүр сумын Соёлын төвийн бүжгийн багш, Алаг-Эрдэнэ сумын соёлын өвийн ажилтан, Галт сумын бүжгийн багш, Хатгал тосгоны Соёлын төвийн дарга, Тариалан сумын Соёлын төвийн бүжгийн багш, Түнэл сумын Соёлын төвийн бүжгийн багш, Улаан-Уул сумын соёлын төвийн өвийн ажилтан, Тосонцэнгэл сумын Соёлын төвийн дарга, Мөрөн сумын бүжгийн багш-2, нийт 9 сумын 10 бүжгийн багш хамрагдлаа.




Жил бүрийн 9 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлдэг “Соёлын ажилтны өдөр”-ийг угтан “Соёлын орон зай” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдамж гарган зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 23 сумын соёлын төв, Төв музей, Хөгжимт драмын театр, Нийтийн номын сан бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. “Соёлын орон зай”-г алслагдсан айл өрх, хөдөөгийн багууд, хилийн застав, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчинд үүсгэж, тэдэнд соёл урлагийн үйлчилгээ үзүүлэв.



Соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн үйл ажиллагаа

Сумын соёлын төвүүд бүсийн урлагийн наадмын үеэр болон Соёлын бүтээлч сарын хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн гаргаж, бүтээлүүдийг нь сурталчлах арга хэмжээг сум орон нутагтаа зохион байгууллаа. Мөн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, сурталчлах, цахим контент хийх зэрэг ажлуудыг олон суманд зохион байгуулсан байна.



Хөвсгөл аймгийн Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар чуулган

12 сарын 15-ны өдөр “Хөвсгөл соёлын мод” Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар чуулганыг зохион байгууллаа. Чуулганд урилгаар СУИС-ын Хөгжлийн хорооны дарга, Доктор Ph.D, дэд профессор Ж.Эрхэмтөгс, аймгийн ИТХ-ын дарга Г.Мөнгөнхуяг, ЗД-ын орлогч М.Хуягбаатар, аймгийн НБХ, ХДТ, ННС, Төв музей, 23 сумын соёлын төвийн дарга, албан хаагчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл зэрэг нийт 120 гаруй хүн оролцлоо. Чуулганы үеэр Доктор Ph.D, дэд профессор Ж.Эрхэмтөгс “Соёлын бүтээлч

үйлдвэрлэл ба орон нутгийн хөгжил” сэдвээр, СУГ-ын дарга Ж.Даваадамдин “Хөвсгөл аймгийн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өнөөгийн байдал” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэг хийлээ.



Чуулганы хүрээнд 23 сумаас шалгарсан гар урлалын үзэсгэлэн, “Хөвсгөлийн зураач урчуудын шилдэг бүтээл шалгаруулах” үзэсгэлэн гарч шилдгүүдийг тодруулан шагнал гардууллаа.





Гар урлалын бүтээл төрөлд:

Байр	Сумын нэр	Оролцогчийн нэр
1-р байр	Чандмань-Өндөр сум	О.Энхжин
2-р байр	Мөрөн сум	Г.Банзрагч
3-р байр	Тариалан сум	Х.Мөнхцэцэг
4-р байр	Эрдэнэбулган сум	О.Нанжид

Хөвсгөлийн зураач урчуудын шилдэг бүтээл шалгаруулах" үзэсгэлэнгийн шагналын эзэд:

Уран бүтээлчдийн нэрс	Шалгарсан төрөл
Бат-Өлзий Ганхөлөг	Чимэглэх урлагийн бүтээлд
Гэндэндагва Баярсайхан	Бэлэг дурсгалын бүтээлд
Ганбат Батзориг	Уран зургийн бүтээлд
Баянжаргал Бат-Эрдэнэ	Орчин үеийн бүтээлд
Одхүү Мягмар	Уран баримлын бүтээлд

“Хөвсгөл гоёл-2022” олон угсаатны хувцас загварын наадам

Хөвсгөл аймгийн 6 угсаатны хувцас загварын уралдаанд 23 сумын 24 загвар зохион бүтээгч 150 гаруй хувцас загвараар өрсөлдлөө. Загварын уралдааныг 6 угсаатны хувцас загвар, өдөр тутмын загвар, тусгай байр номинациар шалгаруулж, 10 сумын 11 зохион бүтээгч тодорч шагналаа гардан авлаа.





Аялал жуулчлалын үзэсгэлэн

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 2 удаагийн аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож аймгийн ХДТ-ын уран бүтээлчид болон ардын авьяастнуудын язгуур урлагийн тоглолтоо толилууллаа.

“Улаанбаатар EXPO-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн



“Ай Ти Эм 2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Хөвсгөл аймаг 2023 оны түнш аймгаар тодорч өмнөх аймгаасаа тугаа гардан авч “Хөвсгөлд зочлох жил” болгон зарлав.



“Хөх сувд-2022” мөсний баярыг 03 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд БОАЖЯ, СЯ, Аймгийн ЗДТГ, аймгийн БОАЖГ, Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба зэрэг байгууллагуудтай, жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Цаатан фестиваль”-ийг “Мон травель” жуулчны

баазтай хамтран зохион байгууллаа. 2022 онд Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан соёлын эвент арга хэмжээ:

- “Хөх сувд”-2022 мөсний баяр
- “Цаатан фестиваль”
- “Дархад дууны наадам”
- “Далийн баяр”
- “Эв модны наадам”
- “Олон угсаатны урлагийн наадам”



Хөвсгөл далайг түшиглэн үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын томоохон баазуудын үйл ажиллагааны хөтөлбөрт Хөгжимт драмын театрын ардын язгуур урлагийн тоглолт хийх хуваарийг тусгаж улмаар аялал жуулчлалын идэвхтэй саруудад хамтран ажилласан.

Аялал жуулчлалын маршрутын дагуу зуны саруудад зохион байгуулсан арга хэмжээ: Хөвсгөл далай эрэгт байрлах зуны “Задгай театр”-т

- ХДТ - Орон нутгийн онцлог бүхий язгуур урлагийн тоглолт 4 удаа
- Төв музей – Нүүдлийн музей /1 сарын турш/

Соёмбо цогцолборт

- ХДТ - Язгуур урлагийн тоглолт 2 удаа

50 100 цогцолборт

- ХДТ - Язгуур урлагийн тоглолт 1 удаа



Цахим бодлогын хэрэгжилтийн хүрээнд

Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан


- Үл хөдлөх дурсгалыг бүртгэх програмд 495 дурсгалт газрын 8546 дурсгал оруулсан. 98,6%
- Соёлын биет бус өвийн бүртгэлийн програмд 905 өвлөн уламжлагчдаас 669 өвлөн уламжлагч буюу 73,9%-ийг оруулсан. /Нас барсан, шилжсэн хүний мэдээллийг хассан учраас хувь багассан харагдаж байна./
- Хөдлөх дурсгалын програмд Төв музей-3718ш үзмэр болон 18 сумын үзмэрийн мэдээллийг оруулсан

Аймгийн 23 сумын номын сангийн сан хөмрөгийг цахим мэдээллийн санд шилжүүлэх ажлыг амжилттай зохион байгууллаа. Номын сангийн электрон каталогт аймгийн ННС нийт номынхоо 90%-ийг, сумдад 10-80%-г оруулаад байна.

Аймгийн Соёл, урлагийн газар 2021 оны 11 дүгээр сараас эхлэн ERP системийг байгууллагын түвшинд ашиглаж эхэлсэн бөгөөд аймгийн Төв музей, Нийтийн номын сан, Хөгжимт драмын театрыг уг системд нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлт, хүний нөөц, цаг бүртгэлийн 3 модулыг ашиглаж тогтмол байна. 23 сумын Соёлын төвөөс 5 сум ERP системийн албан хэрэг хөтлөлтийн модулыг ашиглаж байна. Цаашид сумдын соёлын төвүүдээ ERP систем ашиглаж хэвшихэд арга зүйгээр дэмжлэг үзүүлэх боломж бүрдсэн байна. Соёл, урлагийн газрын албан хаагчид болон салбарын байгууллагуудад төрийн байгууллагын үндэсний цахим шуудан (@khs.moc.gov.mn) домэйн нэр бүхий цахим шуудангийн хаяг үүсгэж хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Соёл урлагийн салбарын нэгдсэн портал <https://khs.moc.gov.mn/> вэб сайтад салбарын байгууллагуудын танилцуулга, ерөнхий мэдээллийг бүрэн оруулсан бөгөөд цаг үеийн мэдээ мэдээлэл, үзвэр үйлчилгээний хуваарийг тогтмол оруулан хөтөлж байна.

Салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан <http://moc.igovernment.mn>, Гүйцэтгэлийн удирдлага мэдээллийн цахим сан <http://plan.igovernment.mn> -д нэвтэрч дарга, мэргэжилтнүүд бүртгэлээ баталгаажуулан ашиглаж эхлэхээр бэлтгэж байна.



☐	shine-ider@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	51.16 MB / 1 GB / 5%
☐	tarialan@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	51.7 MB / 1 GB / 5.05%
☐	tosontsengel@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	50.58 MB / 1 GB / 4.94%
☐	tsagaan-uul@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	66.94 MB / 1 GB / 6.54%
☐	tsagaan-uur@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	356.01 MB / 2 GB / 17.38%
☐	tsagaannuur@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	54.38 MB / 1 GB / 5.31%
☐	tsetsereg@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	51.05 MB / 1 GB / 4.99%
☐	tumurbulag@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	52.12 MB / 1 GB / 5.09%
☐	tunel@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	55.57 MB / 1 GB / 5.43%
☐	ulaan-uul@khs.moc.gov.mn	✓ Unrestricted	74.17 MB / 1 GB / 7.24%

Жендэрийн тэгш байдлыг хангах, зорилтод бүлгийн иргэдэд соёлын үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр

Салбарын нийт албан хаагчдын 57,43% буюу 127 эмэгтэй, 42,57% буюу 106 нь эрэгтэй байна. Ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын мэдээ, жендэрийн тэгш байдлыг хангах талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж аймгийн НБХ-т хүргүүлээ. Соёл урлагийн газраас “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян”-ыг байгууллагын фэйсбүүк хуудсаар 16 хоногийн турш сурталчлан ажилласан бөгөөд аймгийн салбарын ажилтан, албан хаагчидтай уулзалт зохион байгуулж “Цагаан туузтаны хөдөлгөөн”-д хамтдаа нэгдлээ.

Уулзалтын үеэр Хөвсгөл аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын референт М.Тунгалагмөрөн ЖЕНДЕР БА ХҮНИЙ ЭРХ СЭДВЭЭР, Аймгийн эрүүл мэндийн газрын сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ “АЖЛЫН БАЙРНЫ СТРЕСС” сэдвээр салбарын ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэж хэлэлцүүлэг хийлээ.



Хөвсгөл аймагт "Нэгдүгээрт хүүхэд" аймгийн Хүүхдийн XI чуулган зохион байгуулагдлаа. Чуулганы үеэр салбарын санаачилга болон зарим хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл өгөв. “Хөшиг нээгдэх бүрд хүргэх нэг үг”, “Хүүхэд хөгжлийн хувь” уриалгад салбарын бүх байгууллага нэгдсэн ба “Хөвсгөл-Ид шидийн орон” байгуулах төсөлд соёлын салбарын ажилтан албан хаагчид нэг өдрийн цалингаа хандивлан дэмжиж оролцлоо. Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан аймгийн Соёл урлагийн газраас бага насны хүүхдүүдийн дунд “Цэнхэр баавгай дуулж байна” хүүхдийн дууны уралдаан, аймгийн Утга зохиолын нэгдлийн 70 жилийн ойн хүрээнд “Хөх зул” хүүхдийн яруу найргийн наадам зохион байгууллаа.



Шинэ-Идэр сумын Соёлын төвд “Монгол ёс заншлын өргөө” байгуулж, Бүрэнтогтох, Рашаант, Улаан-Уул, Чандмань-Өндөр, Хатгал, Улаан-Уул сумдын номын санг “Хүүхэд хөгжлийн төв” болгон тохижуулав. Ингэснээр тухайн сумдын иргэд, хүүхэд, залуус Соёлын төв, нийтийн номын сангаараа үйлчлүүлэхдээ уламжлалт түүх, соёлоо танин мэдэх боломжоор хангагдсан юм.

Салбарын байгууллагууд зорилтод бүлгийн иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг дор бүрнээ зохион байгуулан ажилласан бөгөөд жишээлбэл Улаан-Уул, Цагаан-Үүр сумын соёлын төвийн хамт олон “Зорилтод бүлгийн иргэддээ хүрч урлаг соёлын үйл ажиллагааг хүргэе”, “Соёлын довтолгоо” уриалгыг дэвшүүлж гэртээ байнгын асаргаанд байдаг иргэд болон 90-с дээш ахмадуудын гэрт очиж урлагийн тоглолтоор үйлчлэв. Мөн Улаан-Уул сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагчдын нээлттэй хэлэлцүүлгийн үеэр соёлын төвийн орлогын нэг хувийг хандивлалаа. Цагаан-Үүр сумын соёлын төв хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг соёл олон нийтийн ажилд оролцох орчин нөхцөлөөр хангах зорилгоор налуу шатыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Санхүү, хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийн чиглэлээр

“Соёл урлагийн байгууллагын хөрөнгө оруулалт”

№	Төлөвлөсөн ажил	Гүйцэтгэл	Мөнгөн дүн
Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр			
1	Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлж, баяжуулах.	“Саяны цоохор ирвэс ” ХХК шалгарч гэрээний дагуу тоног төхрөөмжийг нийлүүлэн санхүүжилт олгох шатанд явагдаж байна.	10.000.0
2	Орон нутаг судлах музейн байнгын үзүүлэнгийн танхимын гэрэлтүүлгийн системийг иж бүрэн шинэчлэх	Орон нутаг судлах музейн байнгын үзүүлэнгийн танхимын гэрэлтүүлгийн системийг иж бүрэн шинэчлэх ажлыг гэрээний дагуу “Хөвсгөл мөнгөн од” ХХК хийж гүйцэтгэсэн.	20.000.0
3	Сумдын номын сангийн фондыг LIB.U4 цахим санд үе шаттайгаар шилжүүлэх.	Волвес ХХК аймгийн 23 суманд хэрэгжсэн номын сангийн програмыг 10 сумд нийлүүлсэн.	9.000.0
4	Хөвсгөл аймгийн түүх, соёлын тухай ном гаргах	“Соёл-олон ястны өв” арга хэмжээний хүрээнд Хөвсгөл аймгийн түүх соёлын ном 28,996,000 (Хорин найман сая есөн зуун ерөн зургаан мянган) төгрөгөөр “Битпресс” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэсэн.	30.000.0
5	Рашаант сумын соёлын төвийн дээврийн их засвар хийх	Рашаант сумруу эрх шилжүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулан Тэмээн ХХК хийж гүйцэтгэсэн.	30.000.0
Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөр			
6	Нийтийн номын сангийн сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх.	Аймгийн номын сангийн тохижилт гэрэлтүүлэг, номын баяжилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	10.000.0
7	Зураач урчуудын "Хөвсгөлийн цуурай" уран бүтээлийн үзэсгэлэнг тогтмол зохион байгуулж оны шилдгүүдийг тодруулах.	Жил бүр урамжлал болгон зохион байгуулдаг. Зураач урчуудын эвлэл ТББ зохион байгуулан явуулсан.	5.000.0
8	Хөвсгөл аймгийн засаг даргын А/211 захирамжийн дагуу баяр наадмын бэлтгэл ажлын зардал	Аймгийн 90,91 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээний баяр наадын нээлтийн үйл ажиллагааны зардал, хөгжим техник хэрэгсэл авсан.	30.000.0

9	Хөвсгөл аймгийн засаг даргын А/214 тушаалын дагуу Нүүдэлчин Монгол-2022 наадамд оролцох зардал	Нүүдэлчин Монгол -2022 олон улсын фестивальд оролцогчийн зардал дэмжлэг үзүүлсэн.	20.000.0
Нийт дүн			164.000.0
Улсын төсвийн хөрөнгөөр			
10	Хөвсгөл Мөрөн суманд Ахмадын урлаг, соёлын төвийн барилга худалдан авах ажиллагаа зарлагдан барилгын ажил эхэлсэн явагдаж байна.	2022 оны 10 сарын 05-ны өдөр Соёлын яамнаас Хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Д.Буманбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн хяналтын инженер Одгэрэл гэсэн ажлын хэсэг мөн Барилга хөгжлийн төвийн мэргэжилтэн Анхбаяр нарын бүрэлдэхүүнтэй барилга дээр газар дээр нь барилгын ажлын явц нөхцөл байдалтай танилцлаа. Ахмадын соёлын төвийн барилга 50 хувийн гүйцэтгэлтэй байна.	500.000.0
11	Арбулаг сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй “Цэгц мандал” ХХК хийж байна.	Соёлын байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр баригдах Арбулаг сумын барилгын явцтай 2022 оны хагас жилээр танилцсан. 10 сарын 05-ны өдөр Соёлын яамнаас Хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Д.Буманбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн хяналтын инженер Одгэрэл гэсэн ажлын хэсэг мөн Барилга хөгжлийн төвийн мэргэжилтэн Анхбаяр нар газар дээр нь барилгын ажлын явц, нөхцөл байдалтай танилцсан. Арбулаг сумын барилгын ажлыг “Цэгц мандал” ХХК хийж байгаа бөгөөд 70 хувийн гүйцэтгэлтэй байна.	1.789.400
12	Соёлын яамнаас аймгуудын соёл, урлагийн газарт тоног төхөөрөмж авах дэмжлэг	АЗДаргын 2022 оны 3-р сарын 10-ны өдрийн А/72 дугаар захирамжаар СУГазрын нэмэлт санхүүжилтийн дансаар татан төвлөрүүлсэнийг буцаан олгож СУГ-ын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авсан.	15.000.0
13	Соёлын сайдын А/212 тоот тушаал Нийтийн номын сангийн сан хөмрөгийг бүрдүүлэхэд	23 сум болон Номын сангийн номын баяжилтийг сан хөмрөгийг бүрдүүлэн 20183 төрлийн 1099 ширхэг номын баяжилтыг хийсэн.	16.250.0

	шаардагдах санхүүжилт		
14	Нүүдэлчин монгол наадмын шилдэг отог урамшуулал	Нүүдэлчин Монгол -2022 олон улсын фестивальд оролцогчийн зардал дэмжлэг үзүүлсэн.	95.000.0
15	Өвийн тооллого	2022 оны 12 сарын 7-ны байдлаар улсын тооллогын ажил 98.6 %-ийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн хэмжээнд 540 дурсгалт газрын 8588 ш дурсгал тоологдохоос 1.Бүрэнтогтох сумын Мөрөнгийн голын хадны зураг, 2. Галт сумын Өндөр толгойн хадны зураг, 3. Галт сумын Улаан чулууны хадны зураг, 4. Тариалан сумын Зүлэгтийн голын бичээс, 5. Цагааннуур сумын Орьюк хадны бичээс, 6.Ханх сумын Жаргалантын хадны зураг, Сумын хамгаалалтад орших 1.Рэнчинлхүмбэ сумын Цахир өврийн булш- 20ш 2.Рэнчинлхүмбэ сумын Хөгийн голын зүүн эргийн булш,-5ш 3.Рэнчинлхүмбэ сумын Хөгийн өндрийн булш хиргисүүр,-36 ш 4.Цэцэрлэг сумын Хүрэн харганы сайрын буган хөшөө олддоогүй байна.	10.000.0
Нийт дүн			2.425.650.0

Дүгнэлт

Монгол улсын Соёлын яам, ЗГХА Соёл урлагийн газар, аймгийн Соёл урлагийн газрууд байгуулагдсанаар соёлын салбарын нэгдсэн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж байна. Аймгийн Орон нутаг дахь соёл урлагийн салбарын байгууллагууд нэгдсэн бодлого, үүрэг чиглэл, шийдвэрээр хамтран ажилласнаар тодорхой үр дүнд хүрлээ. “Нүүдэлчин Монгол” фестивальд оролцоход аймгийн ЗДТГ, Төв музей, ХДТ, ННС, 23 сумын соёлын төвүүд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан нь тус наадамд тэргүүн байр эзлэхэд ихээхэн хувь нэмэр орууллаа. Аймгийн Утга зохиолын нэгдэл, Зураач урчуудын холбоо зэрэг салбарын байгууллагуудтай хамтарсан олон арга хэмжээг зохион байгуулснаас гадна бусад салбарын байгууллагуудтай хамтран ажиллаж, Аялал жуулчлалын эвентүүд, “Монгол бахархал” аян, “Ураг удам” аян зэрэг олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулав. Хөвсгөл аймгийн түүх соёлыг судалдаг олон эрдэмтэн судлаачдыг урьж “Хөвсгөл судлал” эрдэм шинжилгээний бага хурлыг, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулсан “Соёлын мод” чуулганыг Хөвсгөл аймагт анх удаа амжилттай зохион байгуулав. Нүүдэлчин монгол наадмын тэргүүн байрын шагналын сангаас үр дүнтэй зарцуулалт хийж “Хөвсгөл судлал” ЭШХ, “Соёлын мод” СБҮЭ-ийн чуулган, УЗН-ийн ой “Хөх зул” хүүхдийн яруу найргийн наадам, “Ураг удам” угийн бичгийн уралдаан зэргийг

зохион байгуулснаас гадна уран бүтээлчдийг үе шаттайгаар дэмжих ажлыг хэрэгжүүлж соёлын төвийн ардын авьяастны цомгийн ажил, бүжгийн багш нарын сургалт зэрэгт зарцууллаа.

Цаашид анхаарах болон тулгамдаж буй асуудал

Салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах нэн шаардлагатай байна.

Соёл, урлагийн газрын төсөв санхүүд дэмжлэг үзүүлэх, томилолт, тээвэр шатахууны зардлыг тусгаж өгөх,

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага болох ХДТ, ОНСМ, ННС-г шууд удирдлагаар хангах эрхийг Соёл урлагийн газарт шилжүүлэх. Одоогийн байдлаар эдгээр байгууллага нь аймгийн Засаг даргатай гэрээ хийж, гэрээгээ дүгнүүлж байгаа. Энэ нь ажлын гүйцэтгэл, үр дүн, хяналт үнэлгээ хийх, эргэх холбоотой ажиллах зэрэгт сөрөг үр дагаварыг үүсгэж байна. Сумын соёлын төвийн даргыг тухайн сумдын Засаг дарга томилдог. Гэтэл Төрийн албаны шалгалт өгөөд тэнцсэн иргэнийг ажилд томилох асуудал дээр хэт хойрго хандаж байна. Соёл урлагийн салбарын байгууллагуудыг нэгдсэн босоо удирдлагатай болгох шаардлагатай байна.

Тайлан нэгтгэсэн:

Хянасан:

ТТМТЦАХ Мэргэжилтэн Х.Санчирдулам

Дарга Ж.Даваадамдин